

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/048/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Холбоо. Ол. 21 № 166

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хоол, хүнсний материалын төсөвт өртөг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд аргаар худалдан авч болох бараа, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан буюу 76.8 сая төгрөг байхад шууд гэрээ байгуулан авсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" 31.1.2-т харьцуулалт; гэж заасны дагуу тендер шалгаруулалтын харьцуулалтаар худалдан авалт хийгээгүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

011022011

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>57,272,712.98</u>	<u>119,188,962.32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	36,023,742.98	80,714,410.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	36,023,742.98	80,714,410.24
3121	Төгрөг	36,023,742.98	80,714,410.24
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	36,023,742.98	80,714,410.24
33	АВЛАГА	663,250.00	3,351,523.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,351,523.08
33300	Татаас, санхүүжилтийн авлага	663,250.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	20,585,720.00	35,123,029.00
351	Түүхий эд материал	521,647.00	1,716,647.00
35110	Тусгай зориулалттай материал	521,647.00	521,647.00
35130	Эм боох материал	-	1,195,000.00
354	Хангамжийн материал	20,064,073.00	33,406,382.00
35420	Аж ахуйн материал	18,604,213.00	22,428,882.00
35470	Бусад хангамжийн материал	1,459,860.00	10,977,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,125,280,729.22</u>	<u>6,014,767,507.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,125,280,729.22	6,014,767,507.03
392	Биет хөрөнгө	4,963,469,062.68	4,854,392,507.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,197,307,566.00	5,197,307,566.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(519,134,951.31)	(639,176,213.43)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	16,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,250,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	331,046,285.10	345,174,607.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(230,087,905.25)	(185,358,188.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	192,515,490.01	193,821,330.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(109,227,503.21)	(120,624,673.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	251,273,057.00	251,234,657.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(150,222,975.66)	(196,236,577.74)
393	Биет бус хөрөнгө	1,161,811,666.54	1,160,375,000.00
39301	Програм хангамж	9,776,900.00	7,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,340,233.46)	(7,820,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,160,375,000.00	1,160,375,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,182,553,442.20</u>	<u>6,133,956,469.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>663,250.00</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	663,250.00	-
413	Өглөг	663,250.00	-
4136	Бусад өглөг	663,250.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	663,250.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,181,890,192.20</u>	<u>6,133,956,469.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,181,890,192.20	6,133,956,469.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,609,677,423.28	1,609,677,423.28
51101	Өмч: - төрийн	1,609,677,423.28	1,609,677,423.28
512	Хуримтлагдсан үр дүн	4,405,663,181.96	4,357,729,459.11
51210	Өмнөх үеийн үр дүн	4,497,638,385.18	4,405,663,181.96
51220	Тайланг үеийн үр дүн	(91,975,203.22)	(47,933,722.85)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,549,586.96	166,549,586.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,182,553,442.20</u>	<u>6,133,956,469.35</u>

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2,065,167,462.59	3,209,429,117.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	277,920,801.59	218,208,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	277,920,801.59	218,208,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	277,920,801.59	218,208,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,296,000.00	126,249,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	153,624,801.59	91,959,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,787,246,661.00	2,991,220,717.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,570,181,900.00	2,610,189,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,570,181,900.00	2,610,189,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,064,761.00	381,031,217.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,452,560.00	222,125,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,966,300.00	23,217,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,645,901.00	135,688,247.36
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,078,923,845.81	3,251,969,496.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,078,923,845.81	3,251,969,496.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,033,799,291.39	2,958,959,615.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,242,155,700.98	1,916,144,420.54
210101	Үндсэн цалин	720,149,887.98	1,000,696,517.79
210102	Нэмэгдэл	327,111,556.27	605,360,741.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,010,019.12	198,206,407.99
210104	Урамшуулал	95,884,237.61	111,880,752.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,037,055.00	215,863,367.79
210201	Тэтгэврийн даатгал	106,437,462.70	150,541,304.79
210202	Тэтгэмжийн даатгал	12,568,893.00	17,172,445.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,309,699.30	8,585,772.86
210204	Ажилгүйдлийн даатгал	2,589,654.80	8,569,982.86
210205	Эрүүл мэндийн даатгал	24,131,345.20	30,993,861.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,355,297.00	128,463,900.00
210301	Гэрэл, цахилгаан	23,503,202.00	39,008,300.00
210302	Түлш, халаалт	31,720,000.00	51,038,300.00
210303	Цэвэр, бохир ус	15,132,095.00	38,417,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,032,039.80	75,795,935.99
210401	Бичиг хэрэг	9,981,200.00	6,530,034.00
210402	Тээвэр, шатахуун	23,034,468.00	12,099,932.00
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	3,597,260.80	3,632,480.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	383,600.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,249,111.00	53,149,889.00
2105	Нормативт зардал	106,396,316.71	139,450,678.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	382,690.00	3,584,451.24
210502	Хоол, хүнс	101,530,626.71	122,343,927.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,483,000.00	13,522,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,766,100.00	40,022,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,969,600.00	9,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,240,000.00
210604	Урсгал засвар	2,796,500.00	25,382,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,792,000.00	14,253,000.00
210702	Догоод албан томилолт	7,792,000.00	14,253,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,447,973.29	133,384,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,282,473.29	114,781,854.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,090,000.00	12,000,000.00
210807	Газрын төлбөр	2,470,700.00	6,602,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	253,816,808.61	295,581,859.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,481,293.80	60,737,680.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,884,000.00	1,050,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	202,451,514.81	233,794,178.92

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,124,554.42	293,009,881.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,302,020.00	278,015,035.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,466,000.00	19,154,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,136,400.00	48,251,024.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	209,210,011.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,699,620.00	1,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	809,358.22	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	809,358.22	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,176.20	2,890,408.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,890,408.61
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	12,104,437.49
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	12,104,437.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(13,756,383.22)	(42,540,379.58)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	78,218,820.00	5,393,343.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,393,343.27
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	78,218,820.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(78,218,820.00)	(5,393,343.27)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(91,975,203.22)	(47,933,722.85)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,911,542,661.00	3,117,469,717.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,296,000.00	126,249,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	124,296,000.00	126,249,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,296,000.00	126,249,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,296,000.00	126,249,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,787,246,661.00	2,991,220,717.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,570,181,900.00	2,610,189,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,570,181,900.00	2,610,189,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,064,761.00	381,031,217.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,452,560.00	222,125,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,966,300.00	23,217,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,645,901.00	135,688,247.36
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,877,283,904.80	3,033,173,741.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,877,283,904.80	3,033,173,741.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,832,172,526.58	2,743,054,269.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,242,155,700.98	1,916,144,420.54
210101	Үндсэн цалин	720,149,887.98	1,000,696,517.79
210102	Нэмэгдэл	327,111,556.27	605,360,741.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,010,019.12	198,206,407.99
210104	Урамшуулал	95,884,237.61	111,880,752.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,037,055.00	219,214,890.87
210201	Тэтгэврийн даатгал	106,437,462.70	150,541,304.79
210202	Тэтгэмжийн даатгал	12,568,893.00	17,172,445.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,309,699.30	8,585,772.86
210204	Ажилгүйдлийн даатгал	2,589,654.80	8,569,982.86
210205	Эрүүл мэндийн даатгал	24,131,345.20	34,345,384.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,355,297.00	128,463,900.00
210301	Гэрэл, цахилгаан	23,503,202.00	39,008,300.00
210302	Түлц, халаалт	31,720,000.00	51,038,300.00
210303	Цэвэр, бохир ус	15,132,095.00	38,417,300.00

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	53,707,080.80	60,209,734.99
210401	Бичиг хэрэг	9,259,000.00	6,421,934.00
210402	Тээвэр, шатахуун	23,034,468.00	12,529,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,597,260.80	3,632,480.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	808,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,646,352.00	36,817,350.00
2105	Нормативт зардал	104,348,715.71	150,700,688.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	382,690.00	4,779,451.24
210502	Хоол, хүнс	99,483,025.71	123,598,937.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,483,000.00	22,322,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,808,660.00	42,782,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,344,960.00	9,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,500,000.00
210604	Урсгал засвар	3,463,700.00	27,882,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,792,000.00	14,253,000.00
210702	Дотоод албан томилолт	7,792,000.00	14,253,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,784,723.29	138,770,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,619,223.29	119,817,854.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,090,000.00	12,350,000.00
210807	Газрын төлбөр	2,470,700.00	6,602,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,183,293.80	72,515,180.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,299,293.80	71,465,180.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,884,000.00	1,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,111,378.22	290,119,472.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,302,020.00	278,015,035.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,466,000.00	19,154,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,136,400.00	48,251,024.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	209,210,011.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,699,620.00	1,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	809,358.22	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	809,358.22	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	12,104,437.49
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	12,104,437.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	34,258,756.20	84,295,975.87
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,153,000.00	36,714,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,153,000.00	36,714,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,153,000.00	36,714,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,153,000.00	36,714,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,153,000.00)	(36,714,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	29,105,756.20	47,581,075.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	36,023,742.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,429,330.00	80,714,410.24

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,609,677,423.28	166,549,586.96	4,405,663,181.96	6,181,890,192.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,609,677,423.28	166,549,586.96	4,405,663,181.96	6,181,890,192.20
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,609,677,423.28	166,549,586.96	4,405,663,181.96	6,181,890,192.20
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,609,677,423.28	166,549,586.96	4,405,663,181.96	6,181,890,192.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,609,677,423.28	166,549,586.96	4,405,663,181.96	6,181,890,192.20
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-47,933,722.85	-47,933,722.85
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,609,677,423.28	166,549,586.96	4,357,729,459.11	6,133,956,469.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,732,133,900.00	2,690,774,697.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,732,133,900.00	2,690,774,697.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,473,230,300.00	2,431,913,662.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,808,603,900.00	1,805,344,879.16
210101	Үндсэн цалин	941,653,900.00	972,433,531.79
210102	Нэмэгдэл	524,534,800.00	522,824,186.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	213,173,400.00	198,206,407.99
210104	Урамшуулал	129,241,800.00	111,880,752.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	211,075,400.00	206,720,820.86
210201	Тэтгэврийн даатгал	142,571,000.00	138,047,234.78
210202	Тэтгэмжийн даатгал	17,126,000.00	17,172,445.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,563,100.00	8,585,772.86
210204	Ажилгүйдлийн даатгал	8,563,100.00	8,569,982.86
210205	Эрүүл мэндийн даатгал	34,252,200.00	34,345,384.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,463,900.00	128,463,900.00
210301	Гэрэл, цахилгаан	39,008,300.00	39,008,300.00
210302	Түлш, халаалт	51,038,300.00	51,038,300.00
210303	Цэвэр, бохир ус	38,417,300.00	38,417,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,539,100.00	43,534,584.99
210401	Бичиг хэрэг	4,282,000.00	4,419,434.00
210402	Тээвэр, шатахуун	10,012,200.00	9,436,200.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	3,520,200.00	2,632,480.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,050,000.00	808,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,674,700.00	26,237,950.00
2105	Нормативт зардал	136,904,000.00	134,903,388.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,580,300.00	6,579,451.24
210502	Хоод, хүнс	125,597,600.00	123,598,937.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,726,100.00	4,725,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,933,100.00	41,892,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,971,100.00	11,930,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,500,000.00	5,500,000.00
210604	Урсгал засвар	24,462,000.00	24,462,000.00
2107	Томилголт, зочны зардал	12,363,000.00	12,363,000.00
210702	Дотоод албан томилголт	12,363,000.00	12,363,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,347,900.00	92,250,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,745,300.00	85,647,854.00
210807	Газрын төлбөр	6,602,600.00	6,602,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	(33,559,365.10)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	(33,559,365.10)

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,903,600.00	258,861,035.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	258,903,600.00	258,861,035.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,251,100.00	48,251,024.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	209,210,100.00	209,210,011.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,442,400.00	1,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,732,133,900.00	2,726,614,680.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,612,469,500.00	2,606,950,280.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,612,469,500.00	2,606,950,280.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	119,664,400.00	119,664,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	119,664,400.00	119,664,400.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	66	63
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	44	42
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22	21

2.6 Аудит нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,023,742.98
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	339,523,150.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	339,523,150.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,369,141.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,799,541.38
210101	Үндсэн цалин	28,262,986.00
210102	Нэмэгдэл	82,536,555.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,494,070.01
210201	Тэтгэврийн даатгал	12,494,070.01
2104	Хангамж, бараа материалын зардал	16,675,150.00
210401	Бичиг хэрэг	2,002,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,093,250.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,579,400.00
2105	Нормативт зардал	17,597,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,597,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,860,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,400,000.00
210602	Тавилга	3,040,000.00
210604	Урсгал засвар	3,420,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,890,000.00
210702	Дотоод албан томилолт	1,890,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,450,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,603,080.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,553,080.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,050,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,154,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,154,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,154,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8.61
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	8.61

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	384,213,817.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	384,213,817.36
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,125,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,217,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,870,847.36
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	44,690,667.26
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,023,742.98
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,714,410.24
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	44,690,667.26

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.0 сая төгрөгийн 2 алдааг залруулсан.

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн 3.3 сая төгрөгийн илүү төлөлтийг авлагаар бүртгээгүй байсныг залруулсан.
2. Тооллогоор дутагдсан 11 хөрөнгийг нягтлан, нярваар төлүүлсэн бөгөөд хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 107.4 сая төгрөгийн 5 зөрчилд 3 албан шаардлага өгч, 2 төлбөрийн акт тогтоосон.

3.1 Албан шаардлага

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын Урамшуулал олгох тухай А/206 дугаар тушаалыг үндэслэн үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч болон сан хариуцсан ахлах мэргэжилтэн нарт нийт 4.1 сая төгрөгийн урамшуулал олгосон. Тус А/206 дугаар тушаал нь Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын 5.1-т “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, өр авлагагүй ажилласан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын дагуу шагнаж урамшуулна. гэж заасныг үндэслэл болгосон бөгөөд “Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам” нь Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалаар хүчингүй болсон байна. Хүчин төгөлдөр бус журмыг барьж улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллаас гадна давхардуулж урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглосон заалттай нийцэхгүй. Мөн Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 5-р хавсралтын 2.2-т *Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.* гэсэн заалтыг зөрчсөн.

2. Хоол, хүнсний материалын төсөвт өртөг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд аргаар худалдан авч болох бараа, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан буюу 76.8 сая төгрөг байхад хоол хүнсний материалыг шууд гэрээ байгуулан авсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31-р зүйлийн 31.1-д *Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг дагуу зохион байгуулна: 31.1.2-т харьцуулалт;* гэж заасны дагуу тендер шалгаруулалтын харьцуулалтын аргыг ашиглаагүй.

3. Төрийн албаны цалингийн нэгдсэн системд цалин бодохдоо ирцийн бүртгэлийг буруу оруулснаас үүдэн цалинтай чөлөө авсан албан хаагчдад 2.5 сая төгрөгийн нэмэгдэл цалин

хөлсийг олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42-р зүйлийн 42.1.3-т гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах; гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Төлбөрийн акт

1. Ахмадын санд тайлант оны нийт цалин сангийн 3 хувиас илүү дүнгээр буюу 17.7 сая төгрөгөөр илүү төвлөрүүлсэн. Энэ нь Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 2.1-д “Ахмадын сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ: 2.1.1.аж ахуйн нэгж, байгууллага, өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоос, төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгө;” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Шинэ жилээр ахмадуудыг хүлээн авалтад оруулахаас гадна давхардуулж, гарын бэлэг гардуулахад 6.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 12.4-т Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна. 14.6-д Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ. гэж заасан бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3.1-т “Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна” гэж заасан байна. Ахмадын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3.3-д “Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно”. гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийг авлагаар бүртгээгүй.	1	3,351.5			1	3,351.5	1	3,351.5				
	1	3,351.5			1	3,351.5	1	3,351.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Хууль, журамд зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгосон	1	4,111.0			1	4,111.0					
Тендер зарлаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1	76,850.0			1	76,850.0					
Цалинтай чөлөөтэй албан хаагчдад нэмэгдэл цалин олгосон.	1	2,525.0			1	2,525.0					
Ахмадын санд цалин сангийн 3 хувиас илүү дүнгээр төвлөрүүлсэн.	1	17,659.7	1	17,659.7							
Ахмадын сангаас ахмадад шинэ жилээр хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулахад хөрөнгө зарцуулсан.	1	6,308.6	1	6,308.6							
Дүн	5	107,454.3	2	23,968.3	3	83,486.0					

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

0117
Дугаар ДДА-2025/048/НА-СТА-ТМЗ
А1170311

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоол, хүнсний материалын төсөвт өртөг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд аргаар худалдан авч болох бараа, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан буюу 76.8 сая төгрөг байхад хоол хүнсний материалыг шууд гэрээ байгуулан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна: 31.1.2.харьцуулалт;

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *Шүрэн СЭМЖИДМАА*
АУДИТОР *Б.ОЮУНХЭРЛЭН*



011041522



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 02/18 ДОН-2025/048/НА-СТА-ТЧЗ Чойбалсан хот
А1170311

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч болон сан хариуцсан ахлах мэргэжилтэн нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 4,111.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

011041524

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ОЮУНХЭРЛЭН

И.СЭМЖИДМАА





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 03/19 ДОН-2025/048/НА-СТА-ТНЗ
А 1170311

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 4 албан хаагчид 55 өдрийн цалинтай чөлөө олгохдоо 2,525.1 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйл. Хувийн чөлөө олгох. 100.1.1-д "Ажил олгогч ажилтны хүсэлтээр хувийн чөлөө олгож болно", 100.1.2-т "Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна", 42-р зүйлийн 42.1.3-т "Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" гэж заасантай тус тус нийцэхгүй мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *И.СЭМЖИДМАА*
АУДИТОР *Б.ОЮУНХЭРЛЭН*



011041519



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 01/08 ДДА-2025/048/АА-СТА-ТМЗ Чойбалсан хот
А1170311

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмадын сангийн хөрөнгөөр шинэ жилийн баяраар ахмадуудад гарын бэлэг гардуулахад зориулж 6,308.6 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 12.4.Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 01-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна. 14.6.Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ. Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 3.1.Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна; 3.3.Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 6,308,600 /зургаан сая гурван зуун найман мянга зургаан зуу/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



И.СЭМЖИДМАА

Б.ОЮУНХЭРЛЭН



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 02/09 ДАА-2025/048/НА-СТА-ТМЗ
А11705/1

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмадын санд цалин сангийн 3 хувиас хэтэрсэн, 17,659.7 мянган төгрөгийг илүү төвлөрүүлсэн.

Энэ нь Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ: 2.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, төсөвт байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвөөс цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ахмадын сангийн дансанд илүү төвлөрүүлсэн 17,659,653 /арван долоон сая зургаан зуун тавин есөн мянга зургаан зуун тавин гурав/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Б.ОЮУНХЭРЛЭН



2125050019